

**ГАРЧИГ**

<b>БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА .....</b>	<b>4</b>
1.1. Ерөнхий мэдээлэл .....	4
1.2. Ордын геологийн нөөц .....	6
1.7.1 Цахилгаан хангамж .....	11
1.6.2 Уурхайн гадаад нүүрс тээвэр .....	12
<b>БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....</b>	<b>13</b>
<b>БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....</b>	<b>35</b>
3.1. Нөлөөллийн хэлбэр үргэлжлэх хугацаа .....	35
<b>БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ .....</b>	<b>38</b>
1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	40
3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө .....	43
4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө .....	44
5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	45
7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	47
8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	49
9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	51
10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө .....	52

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн “Утаат минжүүр-2” талбайн булангийн цэгүүдийн солбицол .....	4
Хүснэгт 2. Төслийн ”Утаат минжүүр-А” талбайн булангийн цэгүүдийн солбицол .....	4
Хүснэгт 3. Ил уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөгөө .....	6
Хүснэгт 4. Усан хангамж үзүүлэлт .....	11
Хүснэгт 5. Хэмжилт хийсэн цэгүүдийн газарзүйн байршил .....	21
Хүснэгт 6. Хээрийн судалгааны хэмжилтийн үр дүн .....	22
Хүснэгт 7. Төсөл хэрэгжих талбайн хөрсний агрохими шинж чанар .....	24
Хүснэгт 8. Төсөл хэрэгжих талбайн хөрсний ширхэгийн бүрэлдэхүүн .....	27
Хүснэгт 9. Төсөл хэрэгжих талбайн хөрсний хүнд металлын агууламж .....	28
Хүснэгт 10. Амьтны аймагт үзүүлэх болзошгүй нөлөөллийн үнэлгээ .....	31
Хүснэгт 11. Төслийн талбайн ойролцоо орших малчин өрхүүдийн мэдээлэл .....	33
Хүснэгт 12. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эхүүсвэр .....	35
Хүснэгт 13. 2026 онд хэрэгжүүлэх БОМТ-ний нийт зардал .....	39
Хүснэгт 14. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	40
Хүснэгт 15. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө .....	42
Хүснэгт 16. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ .....	43
Хүснэгт 17. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох төлөвлөгөө .....	44
Хүснэгт 18. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө .....	45
Хүснэгт 19. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	46
Хүснэгт 20. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	47
Хүснэгт 21. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	49
Хүснэгт 22. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	51
Хүснэгт 23. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь .....	52

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. “Эн И Си” ХХК-ийн “Утаат минжүүр хүрэн нүүрс ашиглах” .....	5
Зураг 2. “Эн И Си” ХХК-ийн хэрэгжүүлэх “Утаат минжүүр хүрэн нүүрсний ордыг ашиглах” төслийн талбай .....	5
Зураг 3. Баруун хойд ил уурхайн эцсийн байдлын дэвсгэр зураг .....	7
Зураг 4. Баруун урд ил уурхайн эцсийн байдлын дэвсгэр зураг .....	8
Зураг 5. 8апу 5501 Ю маркийн экскаватор, 8апу 750 маркийн экскаватор .....	9
Зураг 6. ТопдН 875М усалгааны машин .....	10
Зураг 7. Автогрейдер ХОМО ОК2403 .....	10
Зураг 8. Утгуурт ачигч ^968Н ^тд допд .....	10
Зураг 9. ТопдН 875М маркийн автосамосвал .....	10
Зураг 10. МТ86Н маркийн автосамосвал .....	10
Зураг 11. 150 маркийн дизель цахилгаан үүсгэвэр .....	11
Зураг 12. Ытлюпа 250 маркийн дизель цахилгаан үүсгэвэр.....	11
Зураг 13. Төлөвлөж буй гадаад нүүрс тээврийн замын зураг .....	12
Зураг 14. Газрын гадаргын налууугийн эзлэх талбай, га .....	13
Зураг 15. Газрын гадаргын налуу .....	14
Зураг 16. Гадаргын зүг зовхис, эзлэх хувиар .....	15
Зураг 17. Налуугийн зүг зовхис .....	16
Зураг 18. Хур тунадас .....	18
Зураг 19. Агаарын температур .....	20
Зураг 20. Агаарын шинжилгээ хийж буй үйл явц .....	21
Зураг 21. Хэмжилт хийсэн цэгүүд .....	22
Зураг 22. Хөрсний дээж авч буй үйл явц .....	23
Зураг 23. Төсөл хэрэгжих талбайн хөрсөн бүрхэвч .....	24
Зураг 24. Төсөл хэрэгжих талбайн хөрсний рН-ийн түвшин.....	25
Зураг 25. Төсөл хэрэгжих талбайн хөрсний карбонатын агууламж .....	25
Зураг 26. Төсөл хэрэгжих талбайн хөрсний ялзмагийн агууламж .....	26
Зураг 27. Төсөл хэрэгжих талбайн хөрсний ЕС буюу хялбар уусах давсжилтын түвшин ..	26
Зураг 28. Хөрсний хөдөлгөөнт фосфорын хангамж .....	26
Зураг 29. Хөрсний хөдөлгөөнт калийн хангамж .....	27
Зураг 30. Төсөл хэрэгжих талбайн хөрсний механик бүрэлдэхүүн .....	28
Зураг 31. Төслийн талбайн ургамлан бүлгэмдэл .....	29
Зураг 32. Төслийн талбайн орчмын ТХГН-г харуулсан зураг .....	31
Зураг 33. Төсөл хэрэгжих талбайд ойр орших айлуудын хаваржаа намаржааны байршил ..	33
Зураг 34. Өвөлжөө хаваржаа .....	34

## БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Ерөнхий мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр

- “Эн И Си” ХХК

- Улсын бүртгэлийн дугаар: 0711012462

- Регистрийн дугаар: 5155568

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг, утас

- Дорнод аймаг, Хэрлэн сум, 1-р баг, Залуус 2,  
221 тоот

### Төслийн байршил:


“Эн И Си” ХХК-ийн хэрэгжүүлэх “Утаат минжүүр хүрэн нүүрсний орд” төслийн талбай болох Утаат минжүүр-А /М<sup>^</sup>-020975/, Утаат минжүүр-2 /<sup>^</sup>-020976/ дугаарт тусгай зөвшөөрөл бүхий талбайнууд нь Дорнод аймгийн Чойбалсан сумын Энгэр шанд багт, Улаанбаатар хотоос 740 км, Чойбалсан хотоос ЗХ-д зүгт 88 км, Чойбалсан сумаас 35 км зайд байрлаж байна. Төмөр замаас 1 км зайтай. Хамгийн ойрхон авто замын боомт (Хавирга-Архашаат) хүртэл 55 км.

#### Хүснэгт 1. Төслийн “Утаат минжүүр-2” талбайн булангийн цэгүүдийн солбицол

№	Уртраг	Өргөрөг	Өндөр	Тусгай зөвшөөрлийн дугаар
1	11506'25.37"	48043'1.99"	700	МУ-020976
2	11504'2.37"	48043'1.99"	702	
3	11504'2.37"	48044'29.99"	720	
4	11506'25.37"	48044'54.18"	701	

#### Хүснэгт 2. Төслийн “Утаат минжүүр-А” талбайн булангийн цэгүүдийн солбицол

№	Уртраг	Өргөрөг	Өндөр	Тусгай зөвшөөрлийн дугаар
1	11507'32.57"	48043'1.99"	668	М <sup>^</sup> -020975
2	11506'25.37"	48043'1.99"	700	
3	11506'25.37"	48044'54.18"	701	
4	11508'2.38"	48045'26.98"	704	
5	11508'2.36"	48043'5.18"	673	
6	11507'32.57"	48043'5.18"	668	



Зураг 1. “Эн И Си” ХХК-ийн “Утаат минжүүр хүрэн нүүрс ашиглах” төслийн байршлын зураг



Зураг 2. “Эн И Си” ХХК-ийн хэрэгжүүлэх “Утаат минжүүр хүрэн нүүрсний ордыг ашиглах” төслийн талбай

## 1.2 . Ордын геологийн нөөц

Дорнод аймгийн Чойбалсан сумын нутагт орших М<sup>^</sup>-020976 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Утаат минжүүр-2 хүрэн нүүрсний ордын зүүн хэсгийн нөөцийг ЭБМЗ-ийн 2014 оны 04-р сарын 22-ны өдрийн хурлын ХХ-06-08/01 тоот дүгнэлт, нөөц хүлээн авч, бүртгэх тухай АМГ-ын даргын 2014 оны 06-р сарын 09-ний өдрийн 48 тоот тушаалаар бохир хүрэн нүүрсний нөөц боломжтой /С/ зэргээр 50126.1 мян.тн, цэвэр хүрэн нүүрсний нөөц боломжтой /С/ 46710.9 мян.тн-оор хүлээн авч бүртгэсэн.

Утаат минжүүр-2 хүрэн нүүрсний ордын баруун хэсгийн нөөцийг ЭБМЗ-ийн 2021 оны 01-р сарын 21-ний өдрийн хурлын ХХ-21-04 тоот дүгнэлт, нөөц хүлээн авч, бүртгэх тухай АМГТГ-ын даргын 2021 оны 02-р сарын 05-ны өдрийн №10 тоот тушаалаар бохир хүрэн нүүрсний нөөц бодитой /В/ зэргээр 5379.26 мян.тн, боломжтой /С/ зэргээр 9523.18 мян.тн, нийт бодитой ба боломжтой (В+С) зэргээр 14902.44 мян.тн, цэвэр нүүрсний нөөц бодитой /В/ зэргээр 5285.76 мян.тн, боломжтой /С/ зэргээр 9353.01 мян.тн, нийт бодитой ба боломжтой (В+С) зэргээр 14638.77 мян.тн-оор тус тус хүлээн авч бүртгэсэн.

Ордыг ил уурхайн аргаар ашиглах ба ил уурхайн хүрээнд хамаарахгүй нүүрсний нөөц боломжтой /С/ зэргээр 6925.59 мян.тн байна.Тус орд нь II бүлэгт хамаарах тул үйлдвэрлэлийн нөөцийг тооцоходоо Уул уурхайн сайдын 2015 оны 9-р сарын 11-ний өдрийн 203 тоот тушаалыг үндэслэн геологийн В, С зэргийн нөөцийг үйлдвэрлэлийн магадалсан “В” нөөцөд шилжүүлэн тооцов. Ил уурхайн хүрэн дэх нүүрсний нөөц бодитой /В/ зэргээр 5285.76 мян.тн, боломжтой /С/ зэргээр 2427.42 мян.тн нийт (В+С) зэргээр 7713.18 мян.тн байна. Олборлолтын үеийн дундаж хаягдал 13.44 %, бохирдолт 6.07 % байна. Ил уурхайн үйлдвэрлэлийн нөөц магадалсан “В” зэргээр нийт 7081.43 мян.тн байна.

## 1.3 Ил уурхайн жилийн хүчин чадал, ашиглах хугацаа

Утаат минжүүр-2 хүрэн нүүрсний орд нь жилд 2,000.0 мян.тн нүүрс олборлох хүчин чадал бүхий ил уурхайг ажиллуулахаар төлөвлөж байгаа бөгөөд хөрс хуулалтын дундаж итгэлцүүр 1.8 м<sup>3</sup>/тн байна.

Нийт ил аргаар ашиглах уурхайн хүрэн дэх нүүрсний үйлдвэрлэлийн нөөц 7081.43 мян.тн юм. Уурхайн жилийн хүчин чадал нь нөөц ба ил уурхайн ашиглалтын хугацааны хоорондын хамаарлын тооцоогоор 667.84 мян.тн нүүрс олборлохоор гарч байгаа ч захиалагч байгууллагаас өгсөн төслийн даалгаврыг үндэслэн жилд 1.5 сая.тн нүүрс олборлохоор ТЭЗҮ-д тусгасан бөгөөд нийтдээ 6 жил шаардагдахаар байна.

Хүснэгт 3. Ил уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

№	Ашиглалтын жилүүд	Нүүрс		Уулын цул	Хөрс	Хөрс хуулалтын итгэлцүүр	
		мян.мЗ	мян.тн			мян.мЗ	мян.мЗ
1	I жил	617.41	800.00	1513.16	895.76	1.45	1.12
2	II жил	973.64	1261.58	2237.05	1263.41	1.30	1.00
3	III жил	1157.64	1500.00	2680.46	1522.82	1.32	1.02
4	IV жил	1166.50	1500.00	5521.36	4354.86	3.73	2.90
5	V жил	1166.50	1500.00	5305.56	4139.06	3.55	2.76
6	VI жил	404.28	519.86	944.12	539.85	1.34	1.04
7	Нийт дүн	5485.97	7081.43	18201.72	12715.74	2.32	1.80

#### 1.4 Ил уурхайн ажиллах горим


Уурхайн ажиллах горимыг захиалагч байгууллагын техникийн даалгавар, уурхайн жилийн хүчин чадалтай нь уялдуулан дараах байдлаар сонгов. Үүнд:

Жилийн нийт хоног	365 хоног
Үндэсний баяр, ёслолын амралтын хоног	15 хоног
Засвар үйлчилгээ, бэлтгэл ажил	70 хоног
Цаг агаарын нөхцөлийг тооцсон хоног	10 хоног
Уурхайн жилд ажиллах хоног	270 хоног
Хоногт ажиллах ээлжийн тоо	2 ээлж
Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	12 цаг тус тус байна.


##### 1.4.1 Ордыг нээх, ашиглах дараалал

Утаат минжүүр-2 хүрэн нүүрсний орд орчмын газрын гадарга нь жижиг гүвээ толгод зонхилох бөгөөд толгод нь аажмаар тэгш тал газрын байдалд шилждэг. Иймээс уурхайн нээлтэд уул-техникийн хувьд хүндрэл гарахгүй.

Баруун хойд хэсгийн ил уурхайг нүүрсний гарш хэсгээс эхлэн  $U=5400361.94$ ,  $X=358236.74$ ,  $Z=720$  цэгээс  $280$  градусын азимутаар зүүн урдаас баруун хойд зүүн чиглэлд  $15$  метрийн ёроолын өргөнтэй хажуу хоёр хананы налуугийн өнцөг  $50^\circ$  байхаар нүүрсний гарш хэсгээр суналын дагуу хэвтээ траншей нэвтэрч, баруун урд хэсгийн ил уурхайг  $U=5398118.0096$ ,  $X=358682.16$ ,  $Z=1055$  цэгээс  $280$  градусын азимутаар зүүн урдаас баруун хойд зүүн чиглэлд  $15$  метрийн ёроолын өргөнтэй хажуу хоёр хананы налуугийн өнцөг  $50^\circ$  байхаар нүүрсний гарш хэсгээр суналын дагуу хэвтээ траншей нэвтэрч нээнэ.



Зураг 3. Баруун хойд ил уурхайн эцсийн байдлын дэвсгэр зураг



Зураг 4. Баруун урд ил уурхайн эцсийн байдлын дэвсгэр зураг

Ордын ашиглах дарааллыг уурхайн жилийн хүчин чадал нүүрсний давхаргын тогтоц тээвэрлэлтийн зай, ашиглалтын системийн үндсэн үзүүлэлтүүдээс хамааран дараах байдлаар тогтоов.

Шимт хөрс хуулалт: Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.3 метрээс ихгүй зузаантайгаар сийрэгжилтийн ажлыг хийлгүйгээр шууд бульдозероор түрж, утгуурт ачигчаар утган автосамосвалд ачин ил уурхайн үржил шимт хөрсний гадаад овоолгод байрлуулна. Шимт хөрсийг хөрс хуулалтын хослол болох 3.0 м<sup>3</sup>-ын утгуурын багтаамжтай утгуурт ачигч болон 40 тн даацтай автосамосвал болон бульдозерын хослолоор хуулна. Баруун хойд ил уурхайн шимт хөрсийг ил уурхайн зүүн талд уурхайн эцсийн хүрэнээс гадна 120 м зайд 30 град-аас ихгүй налуутай хамгийн ихдээ 4 м өндөртэй овоолго үүсгэх ба баруун урд ил уурхайн шимт хөрсийг ил уурхайн зүүн талд уурхайн эцсийн хүрэнээс гадна 200 м зайд 30 град-аас ихгүй налуутай хамгийн ихдээ 4 м өндөртэй овоолго үүсгэж тус тус хураана. Өрнөлтгүй болсон овоолго, уурхайн бүрэн ашиглагдсан газарт техникийн нөхөн сэргээлт хийсний дараа шимт хөрсөөр хучна. Ирээдүйд уулын ажилд өртөх талбайн шимт хөрсийг хуулж шууд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн газарт ашиглана. Энэ нь шимт хөрсний овоолго хадгалалттай холбоотой зардлыг хэмнэх давуу талтай юм. Урт хугацаагаар хадгалах шаардлагатай овоолгод шимт хөрсийг хадгалах стандартын дагуу үржил шимт чанарыг алдагдуулахгүй байх арга хэмжээг авч хадгална.

Үндсэн хөрс хуулалтын ажил: Үндсэн хөрсний чулуулгийн хатуулаг нь 1У-У1 зэрэглэлд хамаарагдаж байгаа учир хөрсний чулуулгийг авахдаа урьдчилан өрөмдлөг-тэсэлгээний ажлын тусламжтайгаар сийрэгжүүлэлтийн ажлыг хийсний дараа хөрсний гадаад, дотоод овоолгод шилжүүлэх болно. Хөрс хуулалтын ажлын догол нь 6 м өндөртэй байна. Хөрс хуулалтын ажилд 3.5-6.0 м<sup>3</sup>-ийн утгуурын багтаамжтай экскаватор 60-80 тн даацтай авто самосвалууд тус тус ажиллана.

Нүүрс олборлолт: Хөрсний доголтой нэгэн адил олборлолтын догол нь 6 м өндөртэй байна. Нүүрс олборлолтод 4.5 м<sup>3</sup>-ын утгуурын багтаамжтай шууд утгуурт цахилгаан экскаватор, 60 тн даацтай авто самосвалын хослолоор ажиллана.

### 1.5 Ил уурхайн ашиглалтын систем

Утаат минжүүр хүрэн нүүрсний ордын баруун хэсгийг ашиглах ил уурхайд хөрс хуулалт болон нүүрс олборлолтын ажлыг экскавацлалт, автотээвэр, гадаад овоолго гэсэн ил уурхайн үндсэн ашиглалтын системээр гүйцэтгэнэ.

Тус уурхайг баруун хойд биет 670-р үнэмлэхүй түвшин хүртэл, баруун урд биет 650-р үнэмлэхүй түвшин хүртэл 50-60 м гүн ил уурхайн ухаш тус тус үүсгэн нүүрсний давхраасны уналын дагуу дээрээсээ доош гэсэн ерөнхий чиглэлтэй, нүүрсний давхраасны суналын дагуу уулын ажлын ахилттайгаар гүйцэтгэнэ.

Утаат минжүүр-2 хүрэн нүүрсний ордын баруун жигүүрийг ил уурхайн аргаар ашиглах ТЭЗҮ-д захиалагч байгууллагын өгсөн саналын дагуу экскаватор-автосамосвал хосолсон авто тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын систем хэрэглэхээр төсөлд тусгалаа. Хөрс хуулалтын ажлыг урьдчилан өрөмдлөг тэсэлгээний ажлын тусламжтайгаар сийрэгжүүлэлтийн ажлыг хийсний дараа экскаваторын тусламжтайгаар автосамосвалд ачин ил уурхайн гадна байрлах хөрсний овоолгод тээвэрлэн байрлуулна.

### 1.6 Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах техник хэрэгсэл

Уулын ажилд хэрэглэх үндсэн техник, тоног төхөөрөмжүүдийг туслан гүйцэтгэгч аж ахуй нэгжүүдээр гүйцэтгүүлэхээр энэхүү төсөлд тусгалаа. Уурхайд дараах нэр төрлийн техникүүд ажиллахад тохиромжтой. Үүнд:

- > 3.2 м<sup>3</sup> утгуурын багтаамжтай 8А<sup>У</sup> фирмийн 8апу550НО маркийн урвуу утгуурт экскаватор
- > 4.5 м<sup>3</sup> утгуурын багтаамжтай 8А<sup>У</sup> фирмийн 8апу750Н маркийн урвуу утгуурт экскаватор
- > 6.5 м<sup>3</sup> утгуурын багтаамжтай 8А<sup>У</sup> фирмийн 8апу870 маркийн урвуу утгуурт экскаватор
- > 60 тонны даацтай МТ86Н маркийн автосамосвал
- > 80 тонны даацтай ТОН<sup>Б</sup>! 875М маркийн автосамосвал
- > ТО<sup>С</sup>Ы 875М маркийн зам усалгааны машин
- > 3-5.0 м<sup>3</sup>-н шанаганы багтаамжтай 8<sup>О</sup> маркийн утгуурт ачигч
- > 8НА<sup>ТШ</sup> 8<sup>А</sup>-32 маркийн бульдозер
- > Туслах машин, механизм



Зураг 5. Sany 550H<sup>А</sup> маркийн экскаватор, Sany 750 маркийн экскаватор

**Уурхайн зам:** Уурхайн автозамыг байгуулахдаа нүүрс олборлолтын болон хөрс хуулалтын ажлын доголудаас нүүрсний ачих хэсэг хүртэлх, хөрс хуулалтын чулуулгийг гадаад овоолго хүртэл тээвэрлэх зай нь хамгийн бага байхаар тооцож байгуулна. Ил уурхайн

дотоод тээврийн болон гадаад тээврийн замын цэвэрлэгээ, засварын ажилд автогрейдер, зам усалгааны машинуудыг хэрэглэнэ.



Зураг 6. ТопдН 875М усалгааны машин



Зураг 7. Автогрейдер Х6М6 6К2403



Зураг 8. Утгуурт ачигч ^968Н ^шд донд

**Хөрс, нүүрс тээвэрлэлт:** Хөрс, нүүрс тээвэрлэлтэд ажиллах автосамосвалыг нүүрсний ордуудад экскаваторын утгуурын багтаамж болон автосамосвалын даацаас нь хамааруулж сонгодог бөгөөд хөрс, нүүрсийг 2.1-4.1 км зайд тээвэрлэхэд автомашины тэвшний эзлэхүүн /Уа/ болон экскаваторын утгуурын багтаамж /Е/-ийн оновчтой харьцаа 3-5 байна. Төсөлд хөрс хуулалт болон нүүрс олборлолтын ажилд 60 тн болон 80 тн даацтай автосамосвалуудыг ашиглахаар тусгасан байна.



Зураг 9. ТопдИ 875М маркийн автосамосвал



Зураг 10. МТ86Н маркийн автосамосвал

### 1.7 Дэд бүтэц

Ил уурхайн тосгон засварын газрын барилга байгууламжуудыг ил уурхайн амнаас зүүн зүгт 2.5 км байрлуулахаар сонгов.

№	Байгууламжуудын нэр	Эзлэх талбайн	Ил уурхайгаас
		га	км
1	Ил уурхай (хойд)	24.7	-
2	Хөрсний гадаад овоолго(хойд)	18.7	0.8
3	Ил уурхай (урд)	34.6	-
4	Хөрсний гадаад овоолго(урд)	24.2	1.1
5	Тосгон	2.5	2.5
6	Засварын газар	5.9	2.3
	Уурхайн захиргаа		
7	Нийт авто зам	6.4 км	
Бүгд		118.0	

### 1.7.1 Цахилгаан хангамж

Уурхайн цахилгаан хэрэглэгчдийг төвлөрсөн цахилгаан хангамжаас эрчим хүчээр хангах боломжгүй учир дизель цахилгаан үүсгүүрээс цахилгаан эрчим хүчээр хангахаар төсөлд тусгаж байна. Дорнод аймгийн Чойбалсан сумын нутагт оршиж буй Утаат минжүүр-2 хүрэн нүүрсний ордын баруун хэсгийг ил уурхайн цахилгаан хэрэглэгчид нь:

- > Ил уурхайд ажиллах цахилгаан хэрэглэгчид (гэрэлтүүлэг, тэсрэх материалын агуулах);
- > Уурхайн хотхон (Уурхайн захиргаа, халуун ус, хоолны газар, ажилчдын байр);
- > Засварын газар, бусад хэрэглэгчид (Засварын газар, шатахуун түгээх станц, сэлбэгийн агуулах).

Ил уурхайн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр найдвартай хангах зорилгоор 0.4 кВ-ын 150 кВА-гийн хүчин чадалтай 2 ширхэг иж бүрэн дизель цахилгаан үүсгэвэр уурхайн дэргэд барьж байгуулна.

Тосгон болон засварын газрын хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр найдвартай хангах зорилгоор 0.4 кВ-ын 250 кВА-гийн хүчин чадалтай Ытотза төрлийн 1 ширхэг иж бүрэн дизель цахилгаан үүсгэвэр уурхайн дэргэд барьж байгуулна.



Зураг 11. 150 маркийн дизель цахилгаан үүсгэвэр



Зураг 12. Мтютза 250 маркийн дизель цахилгаан үүсгэвэр

ил уурхайн хэрэгцээт технологийн хэрэгцээгээр хэрэглэгдэх усыг ордоос шавхаж буй усаар хангахаар тооцоолсон. Үүнд:

Технологийн зориулалтаар ил уурхайд зөвхөн өрмийн суурь машины тоосжилтыг дарах зориулалтаар,

Нүүрс, хөрсний мөргөцгүүд, овоолгуудад болон тээвэрлэлт хийж буй автосамосвалуудын замын хувьд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлагын дагуу тоосжилтыг дарах зориулалтаар,


Хүснэгт 4. Усан хангамж үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
	Технологийн		
	а. Замын тоосжилт дарах	м3/жил	3400
2	Дотоод хэрэглээ	м3/жил	7614
3	Бусад	м3/жил	575
	Нийт	м3/жил	11589

### 1.6.2 Уурхайн гадаад нүүрс тээвэр

Утаат минжүүр-2 хүрэн нүүрсний ордоос жилд 1.5 сая тн нүүрс олборлон БНХАУ-д экспортлохоор төсөлд тусгасан.

Утаат минжүүр-2 нүүрсний уурхай-Хавирга Ар хашаат хилийн боомт хүртэлх чиглэлд тээвэрлэх нийт зай 68 км. Ашиглагдах зам нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, авто замын тээвэрлэлтийн үйл ажиллагааг сайжруулах, сайжруулсан шороон зам байх юм. Авто тээврээр жилд 1.5 сая.тн нүүрс тээвэрлэнэ.



Зураг 13. Төлөвлөж буй гадаад нүүрс тээврийн замын зураг

## БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


Чойбалсан сумын газарзүйн тогтоц, онцлогийг Монгол орны физик газарзүйн мужлалтыг үндэслэн харууллаа. Физик газарзүйн мужлалд бол газар орныг байгалийн бүхий л нөхцөл буюу геологийн бүтэц, хотгор гүдгэр, уур амьсгал, ус зүй, хөрс, ургамалшил, амьтны аймгийн хам бүрдлийн талаар өөр хоорондоо тодорхой ялгаатай хэсгүүдэд хуваах явдал юм.

Монгол орны физик газарзүйн мужлалд нь 4 их мужид хуваагддаг. Үүнд: ХангайХэнтийн уулархаг их муж, Алтайн уулархаг их муж, Монголын Дорнод талын их муж, Говийн их мужууд ордог. Их муж дотроо мужид, муж дотроо тойрогт хуваагдана.


Чойбалсан сум нь физик газарзүйн мужлалаар Монголын Дорнод талын их мужид багтах бөгөөд Дорнодын тэгш талын мужийн Хэрлэнгийн хойт биеийн талд хамрагдана. Байгалийн нөхцөл байдлаараа уул, хөндий, ой хөвч хосолсон ус, ургамал ногоо жигдэрсэн, ан амьтнаар баялаг нутаг. Нутгийн Шилүүтийн хөндий, Бүрдийн хяр, Уртын хоолойноос хойших газар нутаг бүхэлдээ ойт хээрийн бүсэд хамаарагддаг бол үүнээс урагш газар нутаг хээрийн бүсэд хамаарагддаг. Бутлаг өвслөг ургамалтай, уулын хар хүрэн, жинхэнэ хүрэн хөрс зонхилсон дундаж өндөр уулс, уулс хоорондын хөндий бүхий газар нутагтай.

**Газрын гадаргуу:** Газрын гадаргын өндөржилтийн мэдээллийн Ландсат-8 хиймэл дагуулын 2013 онд Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын (хуучин нэрээр) боловсруулсан 30 метрийн өндөржилттэй тоон мэдээллийг ашиглан тус сумын газрын гадаргын налуужилтыг боловсруулж гаргасан. Гадаргын налуужилт нь газар ашиглалтын зэрэгт нөлөөлөх томоохон үзүүлэлтийн нэг төдийгүй усны үйл ажиллагаатай холбоотойгоор шугаман эвдрэл, хөрсний элэгдэл, эвдрэлд ихээхэн нөлөөлдөг. Түүнчлэн хот суурин байгуулах, газар тариалан эрхлэхэд 0-4 градус хэвгий бүхий газар тохиромжтой байдаг. Чойбалсан сумын газрын гадаргын налуужилтыг 5 ангилалд хуваан үзүүлэв.

Чойбалсан сумын газрын гадарга уул, тал, хөндий хосолсон тул газрын гадаргын налуужилт ихтэй ба налуужилтыг даган үүсдэг хотгор, гүдгэр, хэржигдэлт ихтэй байна. Энэхүү налуужилт өндөр байгаа нь газрын гадаргуугийн налуугийн хэмжээ их байгааг харуулж байна. Иймд энэхүү налуу нь газар ашиглалтын зэрэгт нөлөөлөх томоохон үзүүлэлтийн нэг төдийгүй сумын бүтээн байгуулалт, үйл ажиллагаа, хөгжилд ихээхэн нөлөөлдөг.




Зураг 14. Газрын гадаргын налуугийн эзлэх талбай, га




Зураг 15. Газрын гадаргын налуу

**Гадаргын зүг зовхис:** Газрын гадаргын зөв зовхис нь бэлчээрийн улирлын ашиглалтын байдлыг тодорхойлох, газар тариалан, аж ахуй, бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд чухал ачхолбогдолтой хүчин зүйл болдог. Учир нь салхины чиглэл, хурд, хур тунадасны хангамж, нар гийгүүлэлт, гадаргын температур, хөрс ургамлын хэв шинжийн тархалт зэрэг нь зүг зовхисоос ихээхэн хамааралтай байдаг. Сумын нийт нутаг дэвсгэрийн 12.1 хувийг баруун зүг буюу 247.5 - 292.5 градусын зүг, 16.9 хувийг зүүн зүг буюу 67.5-112.5 градусын зүг зовхис, 13.8 хувийг баруун урд зүг буюу 202.5-247.5 градусын зүг зовхис, 13.1 хувийг зүүн хойд зүг буюу 22.5-67.5 градусын зүг зовхис, 7.7 хувийг баруун хойд зүг буюу 292.5-337.5 градусын зүг зовхис, 15.4 хувийг зүүн урд зүг буюу 112.5-157.5 градусын зүг зовхис, 13.7 хувийг урд зүг буюу 157.5-202.5 градусын зүг зовхис, 4.3 хувийг хойд зүг тус тус эзэлж байна.



Зураг 16. Гадаргын зүг зовхис, эзлэх хувиар



Зураг 17. Налуугийн зүг зовхис

**Дорнод аймгийн уур амьсгалын горим:** Байгаль орчны эмзэг тогтоцтой, эрс тэс уур амьсгал нь байгаль орчны болон нийгэм эдийн засгийн амьдралд сөрөг нөлөө үзүүлж байна. Эрт дээр үеэс дан ганц нүүдлийн мал аж ахуйг эрхэж байсан нь байгаль орчин, уур амьсгалын нөхцөлтэй шууд холбоотой байсан ба өнөөгийн зах зээлийн чөлөөт эдийн засгийн орчинд газар ашиглалтын олон хэлбэр, зориулалт нэмэгдсэний зэрэгцээ хүн ам, малын тоо нэмэгдсэн нь газар, байгаль, цаг уурт өөрчлөлтөд ихээхэн орж байна. Иймд тухайн сумын уур амьсгалын өнөөгийн төлөв байдал, цаашдын өөрчлөлтийн чиг хандлагыг судлах нь сумын нутаг дэвсгэрийн хөгжлийг чиглүүлэх ач холбогдолтой тул төлөвлөгөөнд тусгаж ашиглах шаардлагатай байна.


Дорнод аймгийн Чойбалсан сумын хувьд уур амьсгалын мужлалаар нутгийн хойд хэсэг Дулаавтар зунтай, хагас чийглэг мужид, нутгийн төв болон урд хэсэг Дулаан зунтай чийгээр дутмаг мужид хамрагдаж байна.

Дулаавтар зунтай хагас чийглэг уур амьсгалын муж нь Хэнтий, Хангай (далайн түвшнээс дээш 1000-1500 м хүртэл өндөр өргөгдсөн) захын дундаж өндөрлөг уулс багтана. Энд зуны улирлын идэвхтэй температурын нийлбэр 1500-20000 -ын дотор хэлбэлзэх бөгөөд чийг дулааны коэффициент 1.0-1.8-д хүрнэ.

**Хур тунадас:** Агаар мандлын орчил урсгал, орон нутгийн хотгор гүдгэрийн байдал, дэвсгэр гадаргын ууршил зэргээр хур тунадасны горим тодорхойлогдоно. Монгол орны хур тунадасны хэмжээ нь газар зүйн өргөргийн дагуух газар зүйн нам өргөргөөс өндөр өргөрөг рүү шилжих тусам эрс ихэсдэг байна. Энэ нь газрын өндөршилтэй шууд холбоотой байдаг. Жишээлбэл 7 сард хойд өргөргийн 42 градусын бүслүүр дээр 31 мм, өргөргийн 46 градусын бүслүүр дээр 52 мм, өргөргийн 50 градусын бүслүүр дээр 96 мм хур тунадас тус ордог байна. Энэ зүй тогтол жилийн хамгийн хүйтэн 1-р сард мөн жилийн нийлбэр үед ч гэсэн хадгалагдаж байна.

Агаар мандлын орчил урсгал, орон нутгийн хотгор гүдгэрийн байдал, дэвсгэр гадаргын ууршилт зэргээр хур тунадасны горим тодорхойлогдоно. Агаарын жилийн дундаж харьцангуй чийгшил 45-50%. Олон жилийн дундаж жилд унах хур тунадасны хэмжээ 275-300 мм унадаг.

Сүүлийн 5 жилийн байдлаас харвал жилд дунджаар 219.8 мм тунадас унадаг ба бэлчээрийн ургамлын ургалтын хугацаанд хүрэлцэхүйц чийгтэй. Нутгийн ноёлох салхи нь баруун хойноосоо буюу хойноосоо ихэвчлэн салхилдаг. Хамгийн их салхилдаг үе бол 3-5-р сар юм.




Зураг 18. Хур тунадас

**Агаарын температур:** Монгол орны газар нутаг гадаад далай тэнгисээс ихээхэн алслагдсан, Евроазийн эх газрын төвд тал бүрээсээ өндөр уул нуруугаар хүрээлэгдсэн, далайн түвшнээс дунджааркилометр хагас илүү өндөр өргөгдсөн зэргээс шалтгаалан эх газрын эрс тэс, хатуу ширүүн уур амьсгалтай. Монгол орны уур амьсгалын гол онцлог бол жилийн дөрвөн улирлын ялгаа ихтэй, энэ чанараараа агаарын температурын хэлбэлзэл өндөр, хур тунадас бага, уур амьсгалд өргөргийн болон өндрийн бүслүүрийн ялгаа тодорхой илэрдэг явдал юм. Монголд богино (VI сараас VIII сарын дунд хүртэл үргэлжлэх), хуурай зун, ихээхэн хүйтэн, урт (XI сараас IV сар хүртэл үргэлжлэх) өвөлтэй, хавар намрын улирлын үргэлжлэх хугацаа жилээс жилд өргөн хүрээнд хэлбэлздэг онцлогтой.

Манай орны мал сүрэг жилийн дөрвөн улиралд байгаль цаг уурын байнгын нөлөөлөл дор бэлчээрийн маллагаатай байдаг тул цаг агаарын огцом өөрчлөлт, эрс тэс уур амьсгал нь мал сүргийн тогтвортой өсөлтийг хангах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх, түүний эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд багагүй бэрхшээл учруулдаг. Өөрөөр хэлбэл эрс тэс уур амьсгал малын амьдрах чадамж цаг агаар, уур амьсгалын нөхцөлөөс хамааралтай байдаг болохоор цаг агаарын үзүүлэлтийн хэлбэлзэл малын дулаан солилцоо, амьдралын үйл ажиллагаанд шууд нөлөөлж түүний үр дагавар нь ашиг шимийн өөрчлөлтөөр илэрнэ.

Агаарын хоногийн дундаж температурын 0 градуст шилжих шилжилтийн үе 4-р сарын 15 юм. 00- аас дээш температуртай байх хугацаа 134 хоног байгаа бөгөөд эхний хүйтрэлт 8-р сарын 30-нд эхэлдэг ба сүүлчийн хүйтрэлт 3-р сарын 6-10-ны хооронд болдог байна.



Зураг 19. Агаарын температур

**Агаарын чанар:**

Дорнод аймгийн Чойбалсан сумын нутагт орших Овоотын нүүрсний ордыг олборлон нүүрс экспортод гаргахаар төлөвлөсөн. Төслийн ТЭЗҮ-д 6 жилийн хугацаанд 7081.43 мян.тн нүүрс олборлож 18201.72 мян.м<sup>3</sup> уулын цул ухаашаас гаргахаар төлөвлөсөн. 2020 оны 10-р сарын 8-ны өдөр Дорнод аймгийн Чойбалсан суманд байрлах “Эн И Си” ХХК-ийн “Утаат минжүүрийн хүрэн нүүрсний орд” орчмын агаарын чанарын өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох зорилгоор агаарын түгээмэл бохирдуулагч болох хүхэрлэг хий (8O<sub>2</sub>), азотын давхар исэл (№0<sub>2</sub>), нийт тоосонцрын хэмжилт (Т8Р) болон дуу чимээний хэмжилт хийв. Ил уурхайн агаарын чанарын нөлөөлөлд өртөж болзошгүй 4 цэгт нэг удаагийн хэмжилт хийсэн.



Зураг 20. Агаарын шинжилгээ хийж буй үйл явц

Хүснэгт 5. Хэмжилт хийсэн цэгүүдийн газарзүйн байршил

№	Хэмжилтийн цэг	Цэгийн дугаар	Солбицол		Өндөр /м/ д.т.д
			Уртраг E	Өргөрөг ^	
1	Кемп орчим	8P-1	115° 6'7.38"	48°44'39.20	698
2	Худаг орчим	8P-2	115°38'0.33"	48°42'50.46"	756
3	Замын хажууд	8P-3	115°24'48.51"	48°50'35.16"	772
4	Төслийн талбайн гадна	8P-4	115°26'23.38"	48°42'50.46"	736



Зураг 21. Хэмжилт хийсэн цэгүүд

Төсөл хэрэгжих газрын агаарын чанарын судалгаанд нэг удаагийн хэмжилтээр 3 цэгт хүхэрлэг хий(8O<sub>2</sub>), азотын давхар исэл (^O?) болон нийт тоосонцрын (агаарт хөвж байгаа бүх тоосонцор) болон дуу чимээний хэмжилт хийж МК84585:2016 АЧС-ын стандартын ЗДХ утгатай харьцуулав. Хэмжилтийн дүнгээр стандартаас давсан бохирдолгүй байна.

Хүснэгт 6. Хээрийн судалгааны хэмжилтийн үр дүн

№	Цэгийн дугаар	Хэмжилт хийсэн огноо	Хүхэрлэг хий мкг/м <sup>3</sup>	Азотын давхар исэл мкг/м <sup>3</sup>	Нийт тоосонцор /Т8Р/ мкг/м <sup>3</sup>	Дуу Чимээ /ДБА/
1	8P-1	Х/08 09:00	12	17	42	48
2	8P-2	Х/08 11:20	10	13	53	40
3	8P-3	Х/08 18:00	8	14	65	42
4	8P-4	Х/08 20:30	10	16	56	40
Агаарын чанарын стандарт М^84585:2016			450	200	500	60

Түгээмэл агаар бохирдуулагч бодисын агууламж болон дуу чимээний төвшин агаарын чанарын стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнд хэмжигдсэн. Төслийн зүгээс орчны агаарт голлон нөлөөлөх агаар бохирдуулагч бодисууд болох тоос, тоосонцрыг нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд авч үзэв. Ил уурхайн олборлолтын үйл ажиллагаа эхэлснээр уурхайн өрөмдлөг, тэсэлгээ, машин механизмуудын хөдөлгөөн, нүүрсийг ачих, буулгах, тээвэрлэлт, ялгах зэргээс тоос тоосонцор үүсдэг. Мөн уурхайн хүнд машин механизмууд, бүтээгдэхүүн, овоолгын ажил, нүүрс ачиж буулгах үйл ажиллагаа гэх мэт эх үүсвэрүүдээс агаарын бохирдол үүснэ.

**Хөрсөн бүрхэвч:**


“Эн И СИ” ХХК-ийн “Утаат минжүүр хүрэн нүүрсний орд” төслийн талбайн байгаль орчны үнэлгээний ажлын хүрээнд хөрсний хээрийн судалгааг 2020.10.08-нд хийж гүйцэтгэсэн. Талбайн судалгааны явцад 6-н цэгээс өнгөн хөрсний буюу 0-10, 10-20, 20-45, 45-90, 90-100 см гүнээс дээжлэлт хийж 20 ширхэг дээж авсан. Дээжийг авахдаа

“Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд МК8 3298:1990” стандартыг баримталсан.



Зураг 22. Хөрсний дээж авч буй үйл явц

Төслийн талбайд хамаарах газар нь 672-723 метрийн үнэмлэхүй өндөртэй толгод болон тэдгээрийн өргөн бэл хормой, талархаг газарт байрлана. Төслийн талбайд тархсан хөрсөн бүрхэвч нь Монгол орны хөрсний ангиллаар хээрийн бүлэг хөрсний Хархүрэн, хөрсний дэд хэвшинжид багтах чулуурхаг, карбонаттай, ердийн Хархүрэн гэсэн 3 төрлийн хөрснүүд зонхилон тархсан байна. Ердийн Хархүрэн хөрс нь үржил шимийн түвшин дунд зэрэг, бэлчээр болон газар тариаланд зонхилон ашиглагддаг. Харин чулуурхаг ба сайргархаг хөрснүүд нь дан бэлчээрт ашиглагдана.



Зураг 23. Төсөл хэрэгжих талбайн хөрсөн бүрхэвч


Хөрсний дээжүүдэд агро-хими, ус физик шинж чанарын үзүүлэлтүүдийг доорх лабораторийн задлан шинжилгээний аргуудаар ШУА-ийн Газарзүй-Геозкологийн хүрээлэнгийн Хөрс Судлалын лабораторид тодорхойлсон.

Хүснэгт 7. Төсөл хэрэгжих талбайн хөрсний агрохими шинж чанар

Дээжний дугаар	Гүн, см	рНН.О (1:2.5)	СаСО <sub>3</sub> %	Ялзмаг %	ЕС <sub>2.5</sub> й8/г	Хөдөлгөөнт, мг/100г	
						Р <sub>2</sub> О <sub>5</sub>	К <sub>2</sub> О
Зүсэлт-1	0-22	8.12	0.00	1.895	0.041	1.56	17.2
	22-30	7.95	0.00	1.868	0.072	1.49	16.5
	зо;	7.83	8.18	0.416	0.145	0.63	7.3
Зүсэлт-2	0-16	8.21	0.00	1.385	0.235	1.24	14.8
	16-40	7.60	1.82	1.257	4.750	1.17	13.1
Зүсэлт-3	0-15	7.57	0.00	1.754	0.114	1.51	19.4
	15-25	7.62	0.00	1.623	0.109	1.42	18.0
	25-38	7.63	1.38	1.500	0.125	1.35	16.6
Зүсэлт-4	38-50	7.70	12.72	0.641	0.145	0.73	8.5
	0-12	7.90	0.00	3.156	0.137	2.38	27.2
	12-16	8.10	0.00	0.680	0.210	0.94	9.4
	16-45	8.94	1.96	0.603	2.226	0.78	8.1
Зүсэлт-5	45-90	8.90	1.45	0.443	2.203	0.56	6.9
	90-100	8.89	5.09	0.256	2.084	0.41	5.8
	0-15	8.88	0.00	2.332	0.110	1.92	25.7
Зүсэлт-5	15-37	7.77	0.00	2.136	0.090	1.75	23.6
	37-76	7.71	0.00	0.737	0.199	0.83	10.2


Дээжний дугаар	Гүн, см	рНН.О (1:2.5)	CaCO <sub>3</sub> %	Ялзмаг %	ЕС <sub>2.5</sub> й8/т	Хөдөлгөөнт, мг/100г	
						P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
Зүсэлт-6	0-20	7.76	0.00	2.254	0.042	1.86	24.3
	20-50	7.56	0.00	1.620	0.081	1.37	17.1
Зүсэлт-7	0-10	7.52	0.00	1.893	0.033	1.52	19.5
Зүсэлт-8	0-5	7.54	0.00	2.572	0.121	2.19	28.9

**Хөрсний урвалын орчин (рН):** Судалгааны үр дүнгээс (Хүснэгт 41, Зураг 43) харахад хөрсний рН-ийн утгын хэлбэлзэл 7.5-8.9 буюу сул шүлтлэгээс шүлтлэг урвалын орчинтой байна. Төсөл хэрэгжих талбайн хэмжээнд хөрсний урвалын орчин дунджаар 7.9 буюу дунд зэрэг шүлтлэг байна.



Зураг 24. Төсөл хэрэгжих талбайн хөрсний рН-ийн түвшин


**Хөрсний карбонат:** Судалгааны үр дүнгээс (Хүснэгт 41, Зураг 44) харахад хөрсний карбонатын утгын хэлбэлзэл 0.00-12.7% хооронд, зарим цэгүүдэд карбонатын агууламжгүй байна. Нийт цэгүүд дэх карбонатын дундаж агууламж 1.55% буюу карбонатын агууламж сул байна.



Зураг 25. Төсөл хэрэгжих талбайн хөрсний карбонатын агууламж

**Хөрсний ялмаг:** Судалгааны үр дүнгээс (Хүснэгт 41, Зураг 45) харахад өнгөн үе давхаргын ялмагийн утгын хэлбэлзэл 1.3-3.1%-ийн хооронд буюу дунд зэрэг


агууламжтай байна. Харин хөрсний доод үе давхаргуудад 0.4-2.1% буюу бага агууламжтай байна.



Зураг 26. Төсөл хэрэгжих талбайн хөрсний ялзмагийн агууламж


**Хөрсний цахилгаан дамжуулалт (ЕС1.2.5) буюу хялбар уусах давсжилт:**

Судалгааны үр дүнгээс харахад ЕС-ийн утгын хэлбэлзэл 0.03-4.75 д8/т хооронд буюу зүсэлт 2 ба 4-д давсны агууламж өндөр, хэт өндөр, бусад цэгүүд маш сул давсархаг байна.



Зураг 27. Төсөл хэрэгжих талбайн хөрсний ЕС буюу хялбаруусах давсжилтын түвшин

**Хөрсний хөдөлгөөнт фосфор, кали (P<sub>2</sub>O<sub>5</sub>, K<sub>2</sub>O)** Судалгааны үр дүнгээс (хүснэгт 41, зураг 46,47) харахад өнгөн үеийн P<sub>2</sub>O<sub>5</sub>-ЫН утгын хэлбэлзэл 1.2-2.3 мг/100г -ийн хооронд буюу сайн хангамжтай байна. Хөдөлгөөнт калийн хувьд өнгөн үеийн утгын хэлбэлзэл 14.8-28.9 мг/100г -ийн хооронд буюу маш сайн хангамжтай байна.



Зураг 28. Хөрсний хөдөлгөөнт фосфорын хангамж




Зураг 29. Хөрсний хөдөлгөөнт калийн хангамж

**Хөрсний механик (ширхэгийн) бүрэлдэхүүн.** Судалгааны үр дүнгээс (хүснэгт 43, зураг 48) харахад хөрс нь том ширхэгтэй элсэн фракци давамгайлсан элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна.

Хүснэгт 8. Төсөл хэрэгжих талбайн хөрсний ширхэгийн бүрэлдэхүүн

Дээжний дугаар	Гүн, см	Эзлэхүүн жин, гр/см <sup>3</sup>	Ширхэгийн хэмжээ, % (мм-ээр)			Механик бүрэлдэхүүний нэр
			Элс (2-0.05мм)	Тоос (0.05-0.002мм)	Шавар (< 0.002мм)	
Зүсэлт-1	0-22	1.09	70.9	18.0	11.1	Элсэнцэр
	22-30	0.88	77.5	13.2	9.3	Элсэнцэр
	зо;		73.1	16.1	10.8	Элсэнцэр
Зүсэлт-2	0-16	0.86	68.7	20.2	11.1	Элсэнцэр
	16-40	0.87	68.6	19.0	12.4	Элсэнцэр
Зүсэлт-3	0-15	1.25	73.8	15.8	10.3	Элсэнцэр
	15-25	1.32	71.7	17.3	11.1	Элсэнцэр
	25-38	1.06	79.0	11.3	9.8	Элсэнцэр
	38-50		79.7	12.4	7.9	Элсэнцэр
Зүсэлт-4	0-12	1.48	74.6	16.7	8.7	Элсэнцэр
	12-16	1.63	79.0	10.2	10.8	Элсэнцэр
	16-45	1.54	57.0	30.4	12.5	Элсэнцэр
	45-90		61.4	27.4	11.2	Элсэнцэр
	90-100		57.0	30.3	12.7	Элсэнцэр
Зүсэлт-5	0-15	1.28	70.2	19.8	10.1	Элсэнцэр
	15-37	1.27	64.3	23.4	12.2	Элсэнцэр
	37-76	1.44	81.9	7.3	10.8	Элсэн
Зүсэлт-6	0-20	1.03	73.3	17.4	9.3	Элсэнцэр
	20-50	1.15	77.7	14.2	8.2	Элсэнцэр
Зүсэлт-7	0-10		67.4	22.1	10.5	Элсэнцэр
Зүсэлт-8	0-5		58.6	30.4	10.9	Элсэнцэр



Зураг 30. Төсөл хэрэгжих талбайн хөрсний механик бүрэлдэхүүн

**Хөрсний бохирдлын түвшин.** Хөрсөнд хүн, амьтан, ургамлын өсөлт хөгжилтөд сөрөг нөлөө үзүүлдэг, янз бүрийн өвчин үүсгэх эх үүсвэр болдог 12 хүнд металл байдаг. Эдгээрийг дотор нь онцгой хортой (А8, Сд, Сг, РЬ) болон био-идэвхт (Си, Со, Мо, №, 8г, V, 2п) гэж ангилдаг (хүснэгт 44). Судалгааны үр дүнгээс харахад дээрхи металлууд илэрсэн бөгөөд хүлцэх агууламжаас хэтрээгүй хэвийн түвшинд байна.

Хүснэгт 9. Төсөл хэрэгжих талбайн хөрсний хүнд металлын агууламж

Дээжний дугаар	Хөрсний төлөв	Агууламж, мг/кг									
		Аз	са	Сг	РЬ	Со	Си	№	8г	V	2п
Хизе11-1, 0-22 ст	Ердийн	22	<1	26	19	7	13.7	10	157	36	45
Хизе11-2, 0-16 ст		10	<1	32	20	10	13.5	18	202	52	75
Хизе11-3, 0-15 ст		7	<1	25	16	7	12.4	10	109	38	43
Хизе11-4, 0-12 ст		<	<1	20	52	5	25.8	8	141	35	47
Хизе11-5, 0-15 ст		8	<1	32	20	9	18.2	15	181	50	69
Хизе11-6, 0-20 ст		57	<1	30	37	9	18.8	13	188	50	60
Хүлцэх агууламж											
Хортой агууламж											
Аюултай агууламж		100	20	1500	1200	1000	1000	1800	6000	1000	1000

М№ 5850:2019

**Хөрсний эвдрэл, талхагдал.** Хайгуулын талбайн хэмжээнд өнөөгийн байдлаар орон нутгийн чанартай ердийн шороон замд дунд зэрэг талхагдсан 15.9 га, уурхай болон үйлдвэрийн нөлөөлөлд өртөж эвдэрсэн газар байхгүй. Энэ нь нийт талбайн 0.9% болж байна. Үүнийг тооцоолохдоо *denImel* хиймэл дагуулын 2020 оны 5 сарын мэдээ, Е8К1 тар-ийг ашигласан.

Хөрсний судалгааны нөлөөллийн бүсийг 136,2 га талбайгаар тооцсон ба энэхүү талбай шууд нөлөөлөлд өртөхөөр байна. Үүний 81 хувийг дарагдах хөрс үлдсэн 19 хувийг эвдрэлд орох хөрс тус тус эзлэж байна. Шууд нөлөөлөлд өртөх 136,2 га талбайд 222 тн ялзмаг бүхий хөрс устана.

### Ургамлан бүрхэвч:

Төслийн талбайн ургамлын аймгийн төлөв байдлын хээрийн хэмжилт судалгааг 2020 оны 10 сарын 09-11 хооронд хийж гүйцэтгэсэн бөгөөд судалгаагаар том хялганат үндсэн нэг хэвшлийг дагаж 6 жижиг бүлэг эвшил буюу алаг өвс-үетэнт, үетэн алаг өвст, жижиг нуурын хөндийг дагаж хиаг-дэрст, улалж-хиаг-дэрст, агь-хазааргана-том хялганат, гүвээрхэг хэсгээр агь-том хялганат, өмхий шарилж-үетэнт, нам ухаа гүвээт толгодын хэсгийг дагаж агь-үетэнт ургамлан бүлгэмдэл тус тус тохиолдож байна. Төслийн талбайд нийт 7 цэгт ургамлын бүрэн бичиглэл хийсэд тус цэгүүдийн орчимд ургамлын тусгагийн бүрхцийг бүс нутгийн дундаж бүрхэцтэй харьцуулан үзэхэд 4 цэгт бүс нутгийн дунджийн хэмжээнд буюу 60-70 % харин 3 цэгийн ургамлын бүрхэц бүс нутгийн дунджаас бага зэрэг бага байна.



тэжээл болдог давуу талтай. Иймээс “Эн И Си” ХХК нь тухайн орчинд уурхайн үйл ажиллагаа явуулснаар тухайн нутгийн айлуудын бэлчээрт тодорхой хэмжээнд сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна. Тухайн айлуудын мал бэлчээрлэх зайг "Бэлчээр ашиглалтын асуудал" эрдэм шинжилгээний бүтээлийн үр дүнгээр хавар бог мал бэлчээрлэх зайг 2 км, бод мал бэлчээрлэх зайг 4 км гэж үзсэн бөгөөд бэлчээрийн нөлөөллийн радиуст хамаарагдах айлуудад жил бүр өвс тэжээлийн тусламж үзүүлж нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй.

#### **Амьтны төрөл зүйл:**

Судалгааны талбайд 5 багийн 11 овгийн 21 зүйлийн хөхтөн амьтан, 36 зүйлийн жигүүртэн шувуу, 2 зүйлийн хоёр нутагтан, мөлхөгчид байдаг байна. Суурин амьдрах зүйлүүд дотор бүс нутгийн хэмжээнд ховордсон, улаан номонд орсон амьтан цөөн шувуудаас нөмрөг тас, тарважи бүргэд, шилийн сар хөхтөн амьтдаас цагаан зээр бүртгэгдсэн бөгөөд төслийн талбай орчим нутагладаг тул төслийн ашиглалт, үйл ажиллагааг цаашид хийхэд байгаль хамгааллын асуудал Их (өндөр) зэргийн хэмжээгээр тулгарна гэж ойлгож болно.

Хээрийн судалгааны явцад харьцангуй цөөн зүйлийн боловч цагаан зээрийн үржил болон өвөлжих цөм нутаг тул цаашид судалгаа явуулсан цэгт уурхайн олборлолт, зам харгуй гаргаснаар автомашины дуу чимээ, тоосжилтоос үүдэн амьтад дайжих, нүүрс тээвэрлэлтийн явцад машин механизмд дайруулах магадлалтай. Уурхайн үйл ажиллагаа явуулж байх үед тус газар нутагт оршдог амьтны аймагт дам болон шууд байдлаар эергээр болон сөргөөр нөлөөлж болзошгүй. Үүнд:

#### **> Эерэг нөлөөллүүд:**

- Амьтны аймгийн судалгаа, мониторингийн жил бүрийн хяналт үнэлгээ судалгаа нь энэ бүс нутгийн амьтны аймгийн тухай шинжлэх ухааны үндэстэй мэдээллээр хангах ач холбогдолтой.

#### **> Сөрөг нөлөөллүүд:**

- Машин техникийн зорчих хөдөлгөөн болон үйлдвэрийн үйл ажиллагааны үед үүсэх дуу чимээ, тоосжилт зэргээс үүдэн ойр орчимд нутагладаг ан амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдах, нүүрс тээврийн машинд дайруулах;
- Хөрс хуулалтын үед нүх, хөрсөнд орогнох, үүрлэх мэрэгч, мөлхөгч, шувуудын үүр ноохойг сүйтгэх;
- Төслийн хэрэгжилтийн явцад болон төсөл хэрэгжүүлсний дараа ухаж сэндийлсэн газар, хогонд дарагдсан талбай, сөрөг нөлөөлөлд өртсөн талбайг нөхөн сэргээгүйгээс үүдэн амьтад дайжих, үхэж хорогдох,

“Эн И Си” ХХК-ийн “Утаат минжүүр хүрэн нүүрсний орд” төслийг ил аргаар 6 жилийн хугацаатай ашиглах явцад амьтны аймагт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллийг оноот үнэлгээний аргаар нарийвчлан үнэлж доорх хүснэгтээр үзүүлэв.


Хүснэгт 10. Амьтны аймагт үзүүлэх болзошгүй нөлөөллийн үнэлгээ

Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн оноо						нийлбэр	Нөлөөллийн үнэлгээ
	I	A	B	C	0	E		
Олборлолт хийх, хөрс хуулах, овоолго хийх, барилга байгууламж барих, техник хэрэгсэл явах зам тавих, кемп барьсны улмаас эдгээр үйл ажиллагаанд өртсөн талбайн амьтны аймаг, ялангуяа мэрэгчид, шавж, мөлхөгчид устаж үгүй болж тэдгээрийн амьдрах орчин байхгүй болно.	-1	3	3	1	3	2	-12	ИХ
Нүүдлийн амьтад болох цагаан зээр гэх мэт амьтдын нүүдлийн замын зарим чиглэл нь хаагдана.	-1	2	2	2	2	1	-9	Дунд
Ухсан нүх шуудуунууд хашилт хамгаалалтгүй байгаа нь амьтан, мал унах аюултай.	-1	3	2	1	1	3	-9	Дунд
